

Гүйцэтгэх захирлын 2025 оны 04 дүгээр  
сарын 18-ны өдрийн А/54 тоот тушаалын хавсралт



**“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН 2025 ОНЫ АВЛИГЫН  
ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| Д/д | Зорилго                                                                                                                                     | Хэрэгжүүлэх арга хэмжээ                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | Гүйцэтгэлийн үзүүлэлт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
|-----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1   | Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, иргэд олон нийтэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | <p>1.1. Байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудын Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, оруулгын мэдүүлгийг тухай бүрд нь АТГ-т хүргүүлж, хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах;</p> <p>1.2. АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инпографик, бичлэг график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube) мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх;</p> <p>1.3. АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах, дэмжин оролцох, ажилтан, алба хаагчид, иргэдэд түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах.</p> <p>1.4. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 100” мэдээллийн самбар ажиллуулах,</p> | <p>-Баримтжуулж, үр дүнг тооцож тайлагнасан байх;</p> <p>-Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх мэдэгдэл, тайлбарыг үндэслэн холбогдох арга хэмжээг авч ажилласан байх.</p> <p>-Дэмжиж хамтран ажилласан байх;</p> <p>- Салбар нэгж, орон нутаг, зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байх</p> <p>-Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлсэн байх,</p> <p>-Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мэдээллийг байршуулах</p> |
| 2   | Авлигын эсрэг сургалт зохион байгуулах,                                                                                                     | 2.1. АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байх,                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | -Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |

|   |                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                                                                 |
|---|-------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|   | ажилчдаа сургалтад хамруулах                                                              | 2.2. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд залууст хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүнг тооцож тайлагнасан байх                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | -Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байх,<br>-Хамрагдсан хүүхэд залуус иргэдийн тоо                                                                                                                                                                                                              |
| 3 | АТГ-аас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх | 3.1. АТГ-аас хүргүүлсэн зөвлөмж, Мөрдөгчийн мэдэгдэл, Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | -Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу хүргүүлсэн байх,                                                                                                                                                                                                                                                                |
| 4 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх              | 4.1. Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдсэн байдал<br>4.2. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх<br>4.3. Комплайнсын хяналтыг сайжруулах тогтолцоог боловсронгуй болгох<br>4.4. Компанийн эрх бүхий албан тушаалтантай байгуулах гэрээ, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд хүрэх үр дүнг нарийвчлан тогтоох, ажлын гүйцэтгэлийг хэмжигдэхүйц байдлаар тогтоох, хяналт тавих | -Оролцоо<br><br>-Бүх гэрээ, хэлэлцээрт авлигаас ангид байх, мэдээлэх тухай заалт тусгасан байх,<br>-Компанийн дотоод аудитор, хянан шалгах нэгж хэсгийн тайлагнал, зөвлөмж<br>-Эрх бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлага хүлээлгэх механизмыг гэрээнд тусгаж баталгаажуулсан байх. |
| 5 | Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах      | 5.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | -Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байх                                                                                                                                                                                   |
| 6 | Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах                          | 6.1. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4,<br>6.2. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4,<br>6.3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байрлуулж иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах,                                                                                                                                                                                                                                                                                   | -Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарсан байх,                                                                                                                                                                                                               |